



## НИЙСЛЭЛИЙН СОЁЛЫН ТӨВ ӨРГӨӨНИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 11 сарын 16 өдөр

Дугаар A/24

Улаанбаатар хот

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт  
шилжсэн хугацаанд хийх ажлын төлөвлөгөө

Засгийн газрын 2020 оны “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжих тухай” 178 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 34 дүгээр хурлын тэмдэглэл, Нийслэлийн засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/1242 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Хүний гоц халдвар өвчлөлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх талаар Улсын онцгой комиссоос гаргасан “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг албадын дарга нар, хүний нөөцийн ажилтан /П.Сэрсмаа/-д үүрэг болгосугай.
3. Шаардлага гарсан онцгой тохиолдолд “Албан хаагчдад хүргэх дуудлагын схем”-ийн дагуу шуурхай арга хэмжээ авч ажиллахыг хариуцлагатай жижүүрт даалгасугай.

ЗАХИРАЛ *Б.Байгалмаа* Б.БАЙГАЛМАА





Нийслэлийн Соёлын Төв  
Өргөөний захирлын 2020 оны 11  
сарын 16 өдрийн А/124 тоот  
тушаалын нэгдүгээр хавсралт

БҮХ НИЙТИЙН БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ ШИЛЖСЭН ХУГАЦААНД  
ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хийгдэх ажил	Хариуцах албан тушаалтан
1	Засгийн газрын 2020 оны "Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжих тухай" 178 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 34 дүгээр хурлын тэмдэглэл, Нийслэлийн засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/1242 дугаар захирамжуудын тогтоол шийдвэрүүдийг хэрэгжүүлэх, албан хаагчдад танилцуулж гоц халдварт өвчнөөс өөрийгөө, гэр бүлээ, хамаарал бүхий хүмүүсээ хамгаалах талаар заавар зөвлөгөө өгч ажиллах	Захирал, албаны дарга нар
2	Албан хаагчдыг маск зүүлгэж хэвшүүлэх, маск зүүгээгүй иргэнийг ажлын байранд нэвтрүүлэхгүй байх, ажлын байранд ариутгал чийгтэй цэвэрлэгээ тогтмол хийж байх,	Маркетинг үйлчилгээний алба
3	"А" болон "Г" зоны жижүүр дээр ариутгалын бодисыг байршуулж, гаднаас орж ирж буй албан хаагч иргэн үйлчлүүлэгчдийн гарыг ариутгуулах, биеийн халууныг хэмжих,	Санхүүжилт менежментийн алба
4	"Г" зонд ажлын өдрүүдэд хариуцлагатай жижүүр ажиллуулж түрээслэгч байгууллагуудын ажилтан албан хаагчид, тэдэнтэй уулзах иргэдийн бүртгэлийг хөтлөх,	Уран бүтээл техникийн алба
5	Байгууллагын "А" болон "Г" зонд ариутгал халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэх,	Албаны дарга нар
6	ЭМЯ болон мэргэжлийн байгууллагуудаас өгч буй халдвараас хамгаалах заавар зөвлөмжийг хэвлэж, шаардлагатай хэсгүүдэд байршуулах,	Маркетинг үйлчилгээний алба
7	0-12 насны хүүхэдтэй, жирэмсэн эмэгтэйчүүд, архаг өвчтэй ажилтны ажлын цагийг богиносгох, цалинтай чөлөө олгох, гэрээр цахимаар ажил хийх боломж нөхцөлийг бүрдүүлэх,	Санхүүжилт менежментийн алба
8	Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед албан хаагчдад хүргэх дуудлагын схем, албан хаагчидтай холбоо барих утас, гэрийн хаяг бүхий дэлгэрэнгүй бүртгэлийг битүүмжлэн хариуцлагатай жижүүрүүд хүлээлцэж бэлэн байдлыг хангаж ажиллах,	Санхүүжилт менежментийн алба
9	Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд байранд гал гарах, ус алдах, дулаан сантехникийн шугамд гэмтэл үүсэхээс урьдчилан сэргийлэх аюулгүй ажиллагааг хангаж ажиллах,	Инженер техникийн алба
10	Байгууллага хамт олны зүгээс халдварын дам хавьтлаар тусгаарлагдсан Маркетинг үйлчилгээний албаны дарга, үйлчилгээний албан хаагчдын сэтгэл санаа дархлааг дэмжих бүтээгдэхүүнээр эргэлт оруулах,	Албаны дарга нар